



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/439

Хэрлэн сум

“Эзэн Чингисийн түүхийн жимээр” сэдэвт
судалбар уран бүтээлийн ажилд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг байгуулагдсаны 100 жил, Монголын урчуудын эвлэл байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж Баянхутаг, Мөрөн, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров сумдад зохион байгуулах “Эзэн Чингисийн түүхэн жимээр” сэдэвт судалбар уран бүтээлийн ажилд 3,003,200 (гурван сая гурван мянга хоёр зуун) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зарцуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231011056

Аймгийн Засаг даргын 2022
оны ... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо төсөв

| № | Зардлын төрөл | Нэг бүрийн үнэ | Тоо ширхэг | Нийт үнэ |
|----|----------------------|---------------------------------------|----------------|--------------------|
| 1. | Үзэсгэлэнгийн зардал | 50,000 | 12 | 600,000 |
| 2. | Шатахууны зардал | 2520 (АИ-92) 4370 (дизель түлш) | 210 л 200 л | 529,200 874,000 |
| 3. | Жолоочийн хөлс | 200,000 | 2 | 400,000 |
| 4. | Будаг материал | 20,000 | 10 | 200,000 |
| 5. | Рам, хоолст | 25,000 | 12 | 300,000 |
| 6. | Бусад зардал | 10,000 | 10 | 100,000 |
| | | Нийт | | 3,003,200 |